БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# ӨЛЗИЙТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** БНА-2021/133/СТА-ТШЗ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор: Ч.Чимгээ

Утас: 89915909 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ .......... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .......... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .......... 9
3.Аудитын тайлан .......... 9
3.1. Ерөнхий зүйл .......... 9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .......... 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .......... 10
3.4. Материаллаг байдал .......... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .......... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .......... 12
3.7. Шилэн дансны мэдээлэл .......... 13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 13
3.9. Аудитын илрүүлэлт .......... 13
Залруулсан алдаа .......... 14
Аудитын зөвлөмж .......... 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .......... 14
4. Менежментийн захидал .......... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .......... 17



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02.18 № 2/47

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Б.ИЧИНХОРОЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,207,807.61** | **42,469,288.40** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33,207,807.61 | 42,469,288.40 |
| **351** | **Түүхий эд материал** | 5,827,557.80 | 16,773,090.92 |
| 35130 | Эм боох материал | 5,827,557.80 | 16,773,090.92 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,380,249.81 | 25,696,197.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 699,800.00 | 387,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,679,209.00 | 12,089,028.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,053,000.00 | 1,093,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 485,994.00 | 800,000.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 429,300.00 | 359,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 149,460.51 | 255,270.51 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,883,486.30 | 10,712,598.95 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **465,348,892.14** | **1,243,808,397.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 465,348,892.14 | 1,243,808,397.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 458,684,892.14 | 1,237,144,397.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 448,031,700.00 | 1,237,995,610.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,894,584.12 | -39,923,443.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,600,000.00 | 41,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -23,108,333.51 | -29,222,778.03 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 99,388,337.45 | 105,308,337.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -91,910,670.57 | -95,341,503.85 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,982,974.40 | 35,235,474.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,404,531.51 | -18,507,298.68 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,664,000.00 | 6,664,000.00 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -650,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,664,000.00 | 6,664,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **498,556,699.75** | **1,286,277,686.21** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **3,820,448.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 3,820,448.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 3,820,448.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 3,820,448.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **498,556,699.75** | **1,282,457,238.21** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 498,556,699.75 | 1,282,457,238.21 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 198,108,353.00 | 198,108,353.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 198,108,353.00 | 198,108,353.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -157,198,512.38 | 626,702,026.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -157,198,512.38 | -157,198,512.38 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 783,900,538.46 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 457,646,859.13 | 457,646,859.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **498,556,699.75** | **1,286,277,686.21** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **424,999,180.00** | **1,303,604,779.11** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,173,300.00** | **823,153,045.11** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 3,173,300.00 | 823,153,045.11 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,173,300.00 | 823,153,045.11 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,138,500.00 | 823,153,045.11 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **421,825,880.00** | **480,451,734.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 363,231,900.00 | 381,217,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 363,231,900.00 | 381,217,800.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,800.00 | 18,649,334.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,800.00 | 15,602,034.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 3,047,300.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,763,200.00 | 44,565,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,763,200.00 | 44,565,500.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 31,795,980.00 | 36,019,100.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,795,980.00 | 36,019,100.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **440,443,619.94** | **519,704,240.65** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **440,443,619.94** | **519,704,240.65** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 440,267,896.66 | 500,541,833.65 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 268,606,833.00 | 311,563,001.00 |
| 210101 | Үндсэн цалин | 195,512,133.00 | 219,380,672.00 |
| 210102 | Нэмэгдэл | 57,675,400.00 | 70,344,229.00 |
| 210104 | Урамшуулал | 15,419,300.00 | 21,838,100.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,582,900.00 | 41,774,999.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,996,461.45 | 29,330,157.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,542,359.73 | 3,131,326.38 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,156,499.18 | 2,514,959.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 512,993.18 | 602,185.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,374,586.46 | 6,196,370.82 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,672,493.00 | 34,925,083.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,487,993.00 | 1,744,802.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,818,700.00 | 32,986,081.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 365,800.00 | 194,200.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 25,895,090.75 | 23,385,312.98 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,099,060.00 | 1,495,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,044,031.00 | 11,835,611.98 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 820.898.00 | 2,569,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 242,000.00 | 4,400,370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,426,075.00 | 2,654,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,263,026.75 | 430,031.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 34,333,744.00 | 35,966,739.34 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,197,404.00 | 29,814,897.34 |
| 210502 | Хоол, хүнс | 7,136,340.00 | 6,151,842.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 381,500.00 | 955,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 381,500.00 | 955,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 981,000.00 | 1,004,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 981,000.00 | 1,004,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 434,800.00 | 494,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,800.00 | 94,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,379,535.91 | 50,472,898.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,056,060.04 | 14,795,994.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,323,475.87 | 35,676,904.33 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 175,723.28 | 19,162,407.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 15,602,034.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 15,602,034.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 90,707.00 | 723,917.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,707.00 | 723,917.(?) |
| 2135 | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 85,016.28 | 2,836,456.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 85,016.28 | 2,836,456.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-15,444,439.94** | **783,900,538.46** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-17,116,781.34** | **783,900,538.46** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **213,188,259.00** | **480,544,309.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,400.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 23,400.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 23,400.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,400.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **213,164,859.00** | **480,544,309.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 181,090,800.00 | 381,217,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 18,649,334.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 15,602,034.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 3,047,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 16,244,800.00 | 44,565,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,244,800.00 | 44,565,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 15,829,259.00 | 36,111,675.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 14,259.00 | 92,575.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,815,000.00 | 36,019,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **200,062,769.72** | **463,365,309.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **200,062,769.72** | **463,365,309.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **200,048,510.72** | **444,110,327.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 127,679,537.00 | 311,563,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 95,025,577.00 | 219,380,701.13 |
| 210102 | Нэмэгдэл | 28,837,800.00 | 70,344,190.87 |
| 210104 | Урамшуулал | 3,816,160.00 | 21,838,108.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,983,102.00 | 41,775,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,860,516.00 | 29,312,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,185,946.00 | 3,115,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 748,008.00 | 2,492,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 226,960.00 | 623,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,961,672.00 | 6,231,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,584,939.00 | 34,925,083.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 719,779.00 | 1,744,802.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,679,360.00 | 32,986,081.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 185,800.00 | 194,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,970,502.72 | 16,871,218.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 566,300.00 | 1,002,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,995,220.00 | 10,349,618.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 425,732.72 | 2,569,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 983,250.00 | 2,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,251,370.00 | 17,832,732.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,344,990.00 | 11,720,080.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,071,380.00 | 6,112,652.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 835,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,675,000.00 | 2,481,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,275,000.00 | 1,621,000.00 |
| 210602 | Тавилга | 1,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 860,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 546,000.00 | 1,004,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 546,000.00 | 1,004,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 494,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 94,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,958,060.00 | 17,163,494.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,958,060.00 | 17,163,494.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,259.00** | **19,254,982.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,259.00 | 15,694,609.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 14,259.00 | 92,575.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 15,602,034.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 723,917.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 723,917.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,836,456.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,836,456.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **13,125,489.28** | **17,179,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **17,179,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **17,179,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 17,179,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 17,179,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-17,179,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-157,198,512.38** | **00.00** | 498,556,699.75 |
| **2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-157,198,512.38** | **00.00** | 498,556,699.75 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-157,198,512.38** | **00.00** | 498,556,699.75 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 783,900,538.46 | 00.00 | 783,900,538.46 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **626,702,026.08** | **00.00** | 1,282,457,238.21 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 464,248,400.00 | 458,242,027.00 | (6,006,373.00) | 98.71 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 464,248,400.00 | 458,242,027.00 | (6,006,373.00) | 98.71 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 464,248,400.00 | 458,242,027.00 | (6,006,373.00) | 98.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 311,563,000.00 | 311,563,000.00 | - | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 219,380,700.00 | 219,380,700.00 | - | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 70,344,200.00 | 70,344,200.00 | - | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 21,838,100.00 | 21,838,100.00 | - | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,775,000.00 | 41,775,000.00 | - | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,312,500.00 | 29,312,500.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,115,600.00 | 3,115,600.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,492,500.00 | 2,492,500.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 623,100.00 | 623,100.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,231,300.00 | 6,231,300.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,644,900.00 | 34,925,083.00 | (719,817.00) | 97.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,058,300.00 | 1,744,802.00 | (313,498.00) | 84.77 |
| 210302 | Түлш, халаалт | 32,986,600.00 | 32,986,081.00 | (519.00) | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 194,200.00 | (405,800.00) | 32.37 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,006,100.00 | 16,871,218.00 | (1,134,882.00) | 93.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,002,600.00 | (197,400.00) | 83.55 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,280,100.00 | 10,349,618.00 | (930,482.00) | 91.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,576,000.00 | 2,569,000.00 | (7,000.00) | 99.73 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 950,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,485,400.00 | 17,832,732.00 | (3,652,668.00) | 83.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,175,400.00 | 11,720,080.00 | (2,455,320.00) | 82.68 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,112,652.00 | (187,348.00) | 97.03 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,010,000.00 | 00.00 | (1,010,000.00) | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,751,200.00 | 16,707,500.00 | (43,700.00) | 99.74 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,830,600.00 | 7,791,000.00 | (39,600.00) | 99.49 |
| 210604 | Урсгал засвар | 8,920,600.00 | 8,916,500.00 | (4,100.00) | 99.95 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,457,200.00 | 1,004,000.00 | (453,200.00) | 68.90 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,457,200.00 | 1,004,000.00 | (453,200.00) | 68.90 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17165600.00 | 17163494.00 | (2,106.00) | 99.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,165,600.00 | 17,163,494.00 | (2,106.00) | 99.99 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 464,248,400.00 | 461,036,777.00 | -3,211,623.00 | 99.31 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 381,217,800.00 | 381,176,094.00 | -41,706.00 | 99.99 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 381,217,800.00 | 381,176,094.00 | -41,706.00 | 99.99 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 44,565,500.00 | 43,841,583.00 | -723,917.00 | 98.38 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 44,565,500.00 | 43,841,583.00 | -723,917.00 | 98.38 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 38,465,100.00 | 36,019,100.00 | -2,446,000.00 | 93.64 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 38,465,100.00 | 36,019,100.00 | -2,446,000.00 | 93.64 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 20.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 215.00 | 215.00 | 0.00 | 100.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 20.00 | 20.00 | 0.00 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **18,649,334.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **18,649,334.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 3,047,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 3,047,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,047,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 15602034.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 15,602,034.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 15,602,034.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 18649334.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 18,649,334.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 15,602,034.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 3,047,300.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн төвийн дарга Б.Ичинхорол танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ээс 2021 оны 02 дугаар сарын 18–ны хооронд "Баянташаагийн эх аудит" ХХК-ний аудитор Ч.Чимгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт мөн оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 154 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Өлзийт сумын Эрүүл мэндийн төв нь 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан тусламж үйлчилгээний стандартыг мөрдөн, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулан, эрүүл аюулгүй нөхцөлд чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй үзүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 442115,9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8842,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 519704,2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10394,1 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өлзийт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1286277,7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 787721,0 мянган төгрөгөөр буюу 2,5 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт мянган.төгрөгөөр

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 33,207.8 | 42,469.3 | 9,261.5 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 33,207.8 | 42,469.3 | 9,261.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 465,348.9 | 1,243,808.4 | 778,459.5 |
| Үндсэн хөрөнгө | 613,317.0 | 1,427,253.4 | 813,936.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (147,968.1) | (183,445.0) | (35,476.9) |
| **Нийт хөрөнгө** | 498,556.7 | 1,286,277.7 | 787,721.0 |
| Өр төлбөр | - | 3,820.4 | 3,820.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 498,556.7 | 1,282,457.2 | 783,900.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 498,556.7 | 1,286,277.7 | 787,721.0 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 42469,3 мянган төгрөг болж 9261,5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын үлдэгдэл 10945,5 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан. Энэ нь цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эм боох материалын нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1427253,4 мянган төгрөг болж 778459,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 781907,4 мянган төгрөгийн өртөг бүхий эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засварыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 сарын 21 өдрийн 121 тоот тогтоолоор тус эрүүл мэндийн төвийн эзэмшилд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөн тайлант онд төсвийн хөрөнгөөр 17179,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Өвсөн толгойн булан ХХК-аас 7000,0 мянган төгрөгийн автомашин, малчдаас 6610,0 мянган



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгийн тавилга эд хогшил, 1440,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандивласнаас нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1282457,2 мянган төгрөг болж 783900,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1303604,8 мянган төгрөг болж, өмнөх оноос 878605,6 мянган төгрөгөөр буюу 3,1 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 819979,8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос өссөнтэй, тусламж санхүүжилтийн орлого нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 17985,9 мянган, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 17802,3 мянган, нэмэлт санхүүжилт 18614,5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 519704,2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 79260,7 мянган төгрөгөөр буюу 18,0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 42956,2 мянган, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 8162,1 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11252,6 мянган, норматив зардал 1633,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, хангамж бараа материалын зардал 2509,8 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 1906,6 мянган төгрөгөөр тус тус буурсантай байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 478880,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 478880,3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14631,9 мянган төгрөгөөр бууруулж 464248,4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 464248,4 мянган төгрөгийн төсөв баталснаас 381217,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 44565,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 38465,1 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 381176,1 мянган, орон нутгийн төсвөөс 43841,6 мянган, эрүүл мэндийн даатгалын сангаас 36019,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 461036,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 6006,4 мянган төгрөг дутуу зарцуулсан нь томилолтын зардлыг 453,2 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 719,8 мянган, хангамж бараа материалын зардлыг 1134,9 мянган, нормативт зардлыг 3652,7 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 43,7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 6306,4 төгрөгөөр дутуу зарцуулсан нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээний зардал арга хэмжээ 6306,4 мянга, байр ашиглалтын үйлчилгээний зардал 723,9 мянган, нэг хүнд ноогдох нормативт зардал 41,7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

*Хүснэгт 2.* Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган.төгрөгөөр/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71808 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ | 464,248,4 | 458,242,0 | (6306,4) | 98,6 |
| 1.1 | 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 390,551,0 | 385,610,2 | (4940,8) | 98.7 |
| 1.2 | 80109 | Байр ашиглалтын үйлчилгээ | 44,565,5 | 43,541,6 | (723.9) | 98.4 |
| 1.3 | 80302 | Нэг хүнд ноогдох нормативт зардал | 29,131,9 | 29,090,2 | (41,7) | 99,9 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн 18649,4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж эмч Ү.Баттулга, Б.Ууганцэцэг, Ж.Цэцэгмаа, Д.Ганболд нарт хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 15602,0 мянган төгрөг олгож, 3047,3 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлсөн.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлэх мэдээлэл болон хөрөнгө зарцуулах шийдвэр зэрэг 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*Хүснэгт 2.* www.shilendans.gov.mn цахим хуудсанд дахь мэдээлэл

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 86 | 10 | |
| | Нийт | 27 | 151 | 141 | 10 | |

*Эх сурвалж:* www.shilendans.gov.mn цахим хуудас

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1872,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна. Актын хэрэгжилт 100 хувьтай байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1872,0 | 1 | 1872.0 | | | |
| Нийт дүн | 1 | 1872.0 | 1 | 1872.0 | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 3948,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө.

### Залруулсан алдаа

Тухайн оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа байхгүй.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд :

1. **Зардлын данстай холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт* Цалингийн тооцооны хүснэгтээр бодогдсон цалингийн дүн нийгмийн даатгалд мэдээлэгдсэн цалингийн дүнгээс 567,8 мянган төгрөгийн зөрүүтэй байгааг аймгийн НДХ-ийн ААНБ-ын жилийн эцсийн тайлангийн нэгтгэл файлтай тулгахад 1 ажилтны 2258,1 мянган төгрөгийн цалинг илүү, 7 ажилтны 1690,2 мянган төгрөгийн цалинг тус тус дутуу мэдээлэгдсэнээс үүссэн байна.

Энэ нь "үнэн зөв байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх";17 дугаар зүйлийн 17.3-д "нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах тухай албан шаардлага өгөх

Дээрх албан шаардлагын биелэлтийг 2021 оны 5 сарын 15-ны дотор ирүүлэх

### Аудитын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аймгийн ЭМГ-аас нэгдсэн журмаар эмийн тендерийн асуудлыг зохион байгуулж байгаатай холбогдуулан эм болон ороох боох материалын ханган нийлүүлэлтийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай. Тайлант оны эцэст тус эрүүл мэндийн төвийн эргэлтийн эмийн санд 4715751 төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна.

## 4. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний



005

удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тухайн байгууллага, салбартай хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал

1.1Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл байршуулахаас тухай бүр оруулах цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, тендерийн ерөнхий мэдээлэл, жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлэх мэдээлэл болон хөрөнгө зарцуулах шийдвэр зэрэг 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

1.2 Эрсдэл: Мэдээллийн ил тод байдал алдагдах

1.3 Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. Мэдээлэл хоцорсон нь Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албын шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дагуу байршуулсан мэдээлэлд засвар хийсэн тохиолдолд хоцорсон төлөвт шилждгээс шалтгаалсан гэж тайлбар ирүүлсэн байна.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс цаашид анхаарах асуудлын нэг болох эм болон ороох, боох материалын ханган нийлүүлэлтийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх чухал асуудал хэсэгт дурдсан байгаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн удирдлага нарт талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Ч.Чимгээ
Огноо: 2021.02.18

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.18



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Өлзийт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/133/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Өлзийт сумын Эрүүл мэндийн төв | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн тооцооны хүснэгтээр бодогдсон цалингийн дүн нийгмийн даатгалд мэдээлэгдсэн цалингийн дүнгээс 567,8 мянган төгрөгийн зөрүүтэй байгааг аймгийн НДХ-ийн ААНБ-ын жилийн эцсийн тайлангийн нэгтгэл файлтай тулгахад 1 ажилтны 2258,1 мянган төгрөгийн цалинг илүү, 7 ажилтны 1690,2 мянган төгрөгийн цалинг тус тус дутуу мэдээлэгдсэнээс үүссэн байна.. | 3948,3 | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Б.Ичинхорол Ч.Сүрэнлхам |
| 2. | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл байршуулахаас тухай бүр оруулах цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, тендерийн ерөнхий мэдээлэл, жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлэх мэдээлэл болон хөрөнгө зарцуулах шийдвэр зэрэг 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Б.Ичинхорол Ч.Сүрэнлхам |
| | **ДҮН** | **3948.3** | | | |

------oOo------